

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд ард түмэн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан засгийн эрх барих эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”*, Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна”* гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал нь ард түмнээс засгийн эрх барих эрх мэдлээ хэрэгжүүлдэг ард түмний төлөөлөгчдийн байгууллага билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасанчлан, Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхтэй. Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37.1-д Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үйл ажиллагаанаас гадна Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэхээр заасан. Гэвч Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд тухайн этгээдэд хэрхэн хариуцлага хүлээлгэх талаарх зохицуулалт хуульд тодорхойгүй байна. Тиймээс Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд албан үүргээ хангалттай гүйцэтгэж чадаагүй албан тушаалтанд Улсын Их Хурлаас хариуцлага хүлээлгэх талаарх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

**1.2. Практик шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хяналт шалгалт хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2024 онд батлагдсан. Уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д *“Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл ... холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны*

*дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана”* гэж заасан ч хариуцлага алдсан эрх бүхий албан тушаалтанд хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар санал гаргах, шийдвэрлэх зохицуулалт дутуу байна. Үүний улмаас албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн албан тушаалтнууд хариуцлага хүлээхгүй өнгөрөх, төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын хяналт шалгалтыг үл хүндэтгэх нөхцөл байдал бий болж байгаа болно. Тиймээс Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтан хууль зөрчиж албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн бол хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэдэг хуулийн зохицуулалт шаардлагатай байна. Улсын Их Хуралд ажлаа хариуцдаг, удирдлага нь Улсын Их Хурлаас томилогддог дараах албан тушаалтан, байгууллагууд байна. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комисс
- Санхүүгийн зохицуулах хороо
- Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөл
- Үндэсний аудитын газар
- Үндэсний статистикийн хороо
- Төрийн албаны зөвлөл
- Авлигатай тэмцэх газар
- Сонгуулийн ерөнхий хороо
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Шүүхийн сахилгын хороо
- Монгол банкны Ерөнхийлөгч
- Монгол банкны хяналтын зөвлөл
- Монгол банкны мөнгөний бодлогын хороо
- Олон нийтийн радио, телевиз
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл

Эдгээр байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа зарим хуульд албан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл үүргээ ноцтой зөрчсөн албан тушаалтанд хариуцлага оногдуулах талаарх харилцаа зохицуулагдсан байхад заримд нь зохицуулагдаагүй орхигджээ.

Хариуцлага алдсан албан тушаалтанд оногдуулах хариуцлага /санц/ ижил байх нь хууль хүн бүрд тэгш үйлчлэх зарчим хангагдах үндэслэл болно. Тиймээс албан үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй, үүргээ ноцтой зөрчсөн, удаа дараа зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага ижил байлгах практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түүнчлэн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтанд хариуцлага оногдуулах тохиолдолд тухайн шийдвэрийг ямар этгээд санаачлах, хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалт тодорхойгүй байна.

Тухайлбал, Төв банкны тухай хуулийн 26-р зүйлийн 6.4-т Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нь үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх зохицуулалт тодорхой тусгагдсан байна. Гэтэл Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газрын дарга нь үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд чөлөөлөх, огцруулах талаар заагаагүй орхижээ.

### **Хоёр. Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх нь Үндсэн хуулийн зарчим билээ. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтан үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн нөхцөлд зарим нь огцрох, чөлөөлөгдөх санкцтай байхад зарим нь огт хариуцлага хүлээдэггүй байхаар хуульд заажээ. Тиймээс хуулийг нэг мөр биелүүлэх, хариуцлага алдсан албан тушаалтанд хууль тэгш үйлчилдэг байх зарчмыг хангах, түүнчлэн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шийдвэрийг ямар этгээд санаачлах, хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тодорхой болгоход хуулийн төслийн зорилго оршино.

Хуулийн төслийн хувьд хуульд нэмэлт оруулах бүтэцтэй байна. Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан харилцааг хамарч, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулна.

### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо сайжирна. Хэрэв Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын удирдлага үүрэгт ажлаа хангалтгүй гүйцэтгэсэн бол нийтлэг байдлаар хуулийн хариуцлага хүлээдэг эрх зохицуулалт бий болно. Түүнчлэн тухайн зөрчил гаргасан албан тушаалтныг огцруулах санал гаргах, шийдвэрлэх зохицуулалт тодорхой болно. Ингэснээр албан тушаалтнууд ажил үүрэгтээ хариуцлагатай хандах, өргөсөн тангарагтаа үнэнч байх давхар хөшүүрэг бий болж, төрд итгэх итгэл нэмэгдэж, нийгмийн итгэлцэл бэхжих юм.

### **Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд**

## **нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаар Улсын Их Хурал нь Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах эрхтэй байх тул хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн Үндсэн хуульд нийцэж байгаа болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах төсөл боловсруулна.

-oOo-